




МҮХАҮТ

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2022.02.07

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 22.01

ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТУГИЙГ МАНДУУЛЛАА



“Энтрепренер–2021” шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан байгууллагуудын туг өргөх ёслолын ажиллагаа 2022 оны 1 дүгээр сарын 14–нд болж, Гран–Пригаар шалгарсан “Эрдэнэс Тавантолгой” ХК, Ази Номхон Далайн бүсийн ХАҮТ–ын нэгдсэн холбоо (САССИ)–ны шагналт “Петровис групп” ХХК, оны шилдэг аж ахуйн нэгжээр

шалгарсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Оюу толгой” ХХК, “Энержи ресурс” ХХК, ХААН банк, “Мобиком корпораци” ХХК, “Грийн групп” ХХК, “Сүү” ХК, “М Си Эс–Кока кола” ХХК, “Номин холдинг” ХХК, “Ханбогд кашмир” ХХК–ийн тугийг МҮХАҮТ–ын гадна мандууллаа.

УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХЭД ХӨГЖЛИЙН БАНК, МҮХАҮТ ХАМТРАН АЖИЛЛАНА

Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, МҮХАҮТ–ын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар 2022 оны 1 дүгээр сарын 14–нд Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Санамж бичиг байгуулснаар Засгийн газраас хэрэгжүүлэх уул уурхайн бус экспортыг дэмжих санхүүжилтийн

тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр болон төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломж бүрдлээ.

Цаашид уул, уурхайн бус экспортыг дэмжих санхүүжилтийг олгох сонгон шалгаруулалтад хамтарсан ажлын хэсэг

байгуулан ажиллах, Танхимаас тус санхүүжилттэй холбоотой судалгаа шинжилгээг гаргаж шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллахын зэрэгцээ уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр хурал, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах юм.



МҮХАҮТ НЬ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭН ГИШҮҮНЧЛЭЛИЙНХЭЭ ЦАР ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛСЭЭР БАЙНА



МОНГОЛ УЛСААС АНХ УДАА УВСЫН ЧАЦАРГАНА ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫГ ЕВРОПЫН ХОЛБООНД БҮРТГҮҮЛЛЭЭ



ТӨРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ БУУРУУЛАХ БОЛОН ШИНЭЧЛЭХ, САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ, ДҮРЭМ, СТАНДАРТУУДЫН ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ



МҮХАҮТ–ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ О.АМАРТҮВШИН УНГАР УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД БОРБАЛА АННА ОБРУШАНСКИТАЙ УУЛЗЛАА

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ**МҮХАҮТ НЬ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭН ГИШҮҮНЧЛЭЛИЙНХЭЭ ЦАР ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛСЭЭР БАЙНА**

МҮХАҮТ-ын гишүүнээр элссэн компаниудад гэрчилгээ гардуулах арга хэмжээ 2022 оны 1 дүгээр сарын 19-нд боллоо. Шинээр гишүүнээр элссэн гишүүн байгууллагын гэрчилгээг МҮХАҮТ-ын орлогч дарга Б.Намжилсүрэнгардуулав. Энэ үеэр Гишүүнчлэлийн газраас Танхимын үйл ажиллагаа, 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ болон Танхимаас үзүүлдэг

үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл хийж, Монголын Олон улсын арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр арбитрын үйл ажиллагааны талаар, МҮХАҮТ-ын дэргэдэх Комплаенсын зөвлөлийн зөвлөх Б.Батзориг Комплаенсын төлөв байдлын судалгааны тоймыг танилцууллаа.

АНЭУ-ЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД “ДУБАЙ ЭКСПО 2020” ДАХЬ МОНГОЛЫН АСРЫГ ҮЗЭЖ, СОНИРХЛОО

"Дубай экспо 2020" дахь Монгол Улсын асарт АНЭУ-ын Гадаад харилцааны сайд Эрхэмсэг ноён Шейх Абдулла бин Зайд (Sheikh Abdullah bin Zayed) 2022 оны 1 дүгээр сарын 24-нд зочиллоо. Үүний өмнө 2021 оны 10 дугаар сард АНЭУ-ын Угсаа залгамжлах ханхүү, Дубайн Гүйцэтгэх зөвлөлийн дарга

Шейх Хамдан бин Мохаммед бин Рашид Аль Мактум мөн манай улсын асарт зочилсон билээ. Үзэсгэлэн 3 дугаар сарыг дуустал үргэлжлэх бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын асарт 150 мянга гаруй үзэгч зочлоод байна.

МҮХАҮТ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ О.АМАРТҮВШИН УНГАР УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД БОРБАЛА АННА ОБРУШАНСКИТАЙ УУЛЗЛАА

Уулзалтын үеэр хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон юм. Тухайлбал, Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, хотын авто зогсоолуудын менежментийг сайжруулахад Унгар Улсын компанитай хамтран ажиллах, тус улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх, танхимын хууль эрх зүйн орчны талаар болон бусад асуудлаар харилцан туршлага солилцох, газрын гүний эрчим хүч, усан цахилгаан станц зэрэг сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллах,

дэвшилтэт технологийн барилгын материал, пассив хаус технологийг Монгол Улсад нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх талаар тус тус санал солилцлоо.

Уулзалтын дүнд дээрх асуудлуудыг ажил хэрэг болгон, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны хугацаатай төлөвлөгөөг гаргаж ажиллахаар харилцан тохиролцов.



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

МОНГОЛ УЛСААС АНХ УДАА УВСЫН ЧАЦАРГАНА ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫГ
ЕВРОПЫН ХОЛБООНД БҮРТГҮҮЛЛЭЭ

Увсын чацаргана газар зүйн заалт Европын Холбоонд бүртгэгдсэнээр Европын Холбооны гишүүн орнуудад “Увсын чацаргана” газар зүйн заалт хамгаалагдаж, хуурамч бүтээгдэхүүн борлуулагдахаас сэргийлэх, түүнийг зогсоох зэрэг ач холбогдолтой. Түүнчлэн орон нутгийн чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн орлого

нэмэгдэх, тогтвортой бизнес эрхлэлтийг дэмжих, байгаль орчин, цаг уураас шалтгаалсан онцлог амт, чанарыг хадгалах, цаашлаад аялал жуулчлалын шинэ суваг бий болох, хэрэглэгч худалдан авагчид чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн хэрэглэх зэрэг давууталтай.

ТӨРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ БУУРУУЛАХ БОЛОН ШИНЭЧЛЭХ,
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ, ДҮРЭМ, СТАНДАРТУУДЫН
ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

Ерөнхий сайд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 50 хувиар бууруулах, зарим шаардлагагүй шалгалтуудыг цуцлахыг үүрэг болгосонтой холбоотойгоор аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбар болон худалдаа,

үйлчилгээний салбарт төрийн хяналт, шалгалтыг бууруулах болон шинэчлэх, сайжруулах шаардлагатай хууль, дүрэм, стандартуудын ярилцаж, санал боловсруулан Засгийн газарт хүргүүлэх уулзалтыг зохион байгууллаа



**ХӨДӨЛМӨРИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН
ЦОГЦ СУРГАЛТ**

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцогчид болон сонирхон судлагч хүн бүрт нээлттэй

2022.02.09 | 10:00-17:00

СУРГАЛТЫН ТӨЛБӨР
280.000₮

МҮХАҮТ | 99031573, 88104110, 88111799